



# МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН ТУШААЛ

2008 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 71

Улаанбаатар хот

Эрдэм шинжилгээний ажлын хамгаалалтын зардлын  
зээл олгох, тушаалд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 177 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 11 дүгээр тушаалаар батлагдсан “Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг шалгаруулах журам”, захиалагч байгууллагын саналыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яамны захиалгаар ОХУ-ын Дотоод хэргийн яамны дэргэдэх Дорнод Сибирийн их сургуулийн докторантурт суралцаж буй Дамдинсүрэн овогтой Гэрэлбаатарын эрдэм шинжилгээний ажлын хамгаалалтын зардлыг зээлээр олгосугай.

2. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2008 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн 294 дүгээр тушаалын Баасанжав овогтой Гомбодоржтой холбогдолтой хэсгийн “АНУ-ын Калифорнийн Улсын их сургуулийн магистрантурт” гэснийг “Сингапурын SAS сургууль дахь Англи Улсын Cardiff их сургуулийн магистрантурын хөтөлбөрт” гэж өөрчилсүгэй.

3. Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 177 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /Р.Бат-Эрдэнэ/-т тус тус даалгасугай.



Ё.ОТГОНБАЯР